

ИНТЕРНЭТИЙН УРСГАЛААР ХАНГАХ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

..... оны сарын өдөр

№ ИУГ-...../.....

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Нэг талаас **6433553** регистрийн дугаартай “Виртуал линк” ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал ажилтай (Цаашид “Гүйцэтгэгч” гэх), Нөгөө талаас регистрийн дугаартай “.....”-ийн албаны дарга (Цаашид “Хэрэглэгч” гэх) нар Монгол Улсын Иргэний тухай хууль болон бусад хууль тогтоомжинд үндэслэн харилцан тохиролцож, байгуулав.

Нэг. Ерөнхий нөхцөл

- 1.1. Гүйцэтгэгч нь Хэрэглэгчид 24 цагийн турш тасралтгүй Интернэтийн холболтын үйлчилгээг үзүүлэх, хэрэглэгчийн мэдээллийн технологийн ажлуудыг хариуцах (цаашид “ажил” гэх), талууд тус гэрээгээр хүлээсэн эрх үүргээ хэрэгжүүлэн биелүүлэх, үйлчилгээний төлбөр бусад холбогдох тооцоог хийх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гэрээгээр гүйцэтгэх ажлууд нь дараах цар хүрээтэй байна. Үүнд:
 - 1.2.1. Сүлжээ:-ийн дотоод болоод гадаад сүлжээний ашиглалт
 - 1.2.2. Сервер: Хэрэглэгчийн дотоод хэрэгцээний төв сервер компьютер болон хэвийн үйл ажиллагааг хангах;
 - 1.2.3. Интернэт: Харилцаа холбооны зохицуулах хорооны “интернэтийн үйлчилгээ эрхлэх Б ангилалтын тусгай зөвшөөрөл” -тэй интернэт борлуулах үйл ажиллагаа;
- 1.3. Хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд дараах хавсралтуудтай байна. Үүнд:
 - 1.3.1. Хавсралт 1. Талуудын мэдээлэл
 - 1.3.2. Хавсралт 2. Төлбөр тооцоо

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1. Энэхүү гэрээ нь оны сарын-ний өдрөөс эхлэн **2025** оны сарын-ны өдрийг дуустал **1** жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 2.2. Гэрээний хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө Талуудын аль нэг нь гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдэл албан бичгээр гаргаагүй тохиолдолд энэхүү нөхцөл, хугацаагаар дахин 1 жил сунгагдсанд тооцно.
- 2.3. Гэрээг дараах тохиолдолд хугацаанаас өмнө цуцалж болно. Үүнд:
 - 2.3.1. Талууд харилцан тохиролцсоноор,
 - 2.3.2. Талуудын аль нэг гэрээний үүргээ **удаа дараа** биелүүлээгүй ба түүнийг нь албан бичгээр мэдэгдсэн, эсвэл аль нэг үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд нөгөө тал нь гэрээг цуцлах эрхтэй бөгөөд буруутай талд сарын өмнө албан бичгээр мэдэгдэх үүрэгтэй,
 - 2.3.3. Эрх бүхий байгууллагаас аль нэг талын үйл ажиллагааг зогсоосон,

Гурав. Хэрэглэгчийн эрх, үүрэг

- 3.1. Үйлчилгээний талаар Гүйцэтгэгчид санал, хүсэлт гаргах, гүйцэтгэгчээс шалтгаалсан гэмтэл, саатал гарсан тохиолдолд дуудлага өгч үнэ төлбөргүй засварлуулах эрхтэй.

- 3.2. Хэрэглэгч гуравдагч этгээдэд интернэтийн үйлчилгээг холбох, дамжуулан борлуулахыг хориглоно.
- 3.3. Хэрэглэгч тоног төхөөрөмж суурилуулах, тохиргоог Гүйцэтгэгч талд бүрдүүлж өгөх, Суурилуулсан тоног төхөөрөмжүүдийн хадгалалт, хамгаалалт бүрэн бүтэн байдлыг хариуцах үүрэгтэй.
- 3.4. Гэрээг хэрэглэгчийн санаачлагаар хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд анхны үнийн саналд тусгасан 1 удаагийн гарах зардалд туссан зардлыг төлөх үүрэгтэй.
- 3.5. Хэрэв хэрэглэгчийн буруутай, хариуцлагагүй үйлдлээс болж суурилагдсан тоног төхөөрөмж эвдрэл учруулсан тохиолдолд хэрэглэгчийн зардлаар нөхөн төлөх үүрэгтэй.
- 3.6. Хэрэглэгч гэрээнд заасны дагуу төлбөрийг цаг хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй.
- 3.7. Хэрэглэгч нь ашиглаж буй интернэт урсгалаа www.speedtest.net www.fast.com сайтуудаас шалгаж байх үүрэгтэй.

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 4.1. Гүйцэтгэгч нь хэрэглэгчийг 24 цагийн турш тасралтгүй Dedicated **Mbps** гадаад урсгал (дотоод урсгал дамжуулалтыг хязгаарлахгүй) бүхий интернетээр хангах үүрэгтэй.
- 4.2. Гүйцэтгэгч тал тасралтгүй үйлчилгээгээр хангах зорилгоор 24 цагийн турш **Хяналтын инженер** ажиллуулах үүрэгтэй.
- 4.3. Гүйцэтгэгч нь 7 хоногт 2-3 удаа тогтмол хуваарийн дагуу Хэрэглэгчийн байран дээр ирж программ хангамж, компьютерүүдийн зэрэг хэрэглэгчийн мэдээлэл технологийн бүх ажиллагааны хэвийн байдлыг хангаж мэргэжлийн түвшний үйлчилгээг үзүүлж ажиллах үүрэгтэй.
- 4.4. 4.3 т зааснаас бусад гэнэтийн асуудал үүссэн тохиолдолд зайнаас болон биечлэн ирж ажиллана.
- 4.5. Гүйцэтгэгч нь анхны үнийн саналд туссан ажил үйлчилгээг хариуцан ажиллана.
- 4.6. Гүйцэтгэгч нь техникийн болон холболтын шинэчлэлтийг хийх зэрэг зайлшгүй шалтгаанаар үйлчилгээгээр түр зогсоох шаардлага гарвал Хэрэглэгчийн Хавсралт 1-т заасан и-мэйл хаягаар урьдчилан мэдэгдэж холболтыг түр хугацаагаар таслах эрхтэй.
- 4.7. Сүлжээнд гэмтэл саатал гарсан тохиолдолд Гүйцэтгэгч нь Хэрэглэгчийн зөвшөөрлийг авахгүйгээр засварын ажлыг хийж болно.
- 4.8. Засвар, шинэчлэлтийг хийхдээ боломжтой бол шөнийн цагаар хийхийг эрмэлзэж ажиллана.
- 4.9. Хэрэглэгчийн сүлжээнд гэмтэл, саатал гарсан нь Гүйцэтгэгч талын үйлдэлтэй холбоогүй бол тухайн гэмтэл, саатлыг Гүйцэтгэгч тал хариуцахгүй.
- 4.10. Хэрэглэгч энэхүү гэрээний 5.1 заасны дагуу төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд төлбөрийг бүрэн барагдуулах хүртэл үйлчилгээг түр хязгаарлаж болно.
- 4.11. Гүйцэтгэгч талын техникийн үйл ажиллагаанаас хамаарч үйлчилгээ зогссон хугацааны төлбөрийг хасч **тооцно**.
- 4.12. Хэрэглэгчийн мэдээллийн технологийн үйл ажиллагаанд дүгнэлт гаргах, сайжруулах талаар төлөвлөгөө гарган ажиллана.
- 4.13. Сар бүр хийсэн ажлын тайлан, нэхэмжлэхийн хамт гаргаж Хэрэглэгчид өгөх бар түүнийг үндэслэж төлбөр төлөгдөнө.

Тав. Төлбөр тооцоо

- 5.1. **САР БҮРИЙН ТОГТМОЛ ТӨЛБӨР:** Хэрэглэгч нь үйлчилгээний сарын төлбөр нь /..... төгрөг/ байна. Гүйцэтгэгч талын нэхэмжлэлийн дагуу сар бүрийн 25-ны дотор төлнө. Уг үнэд НӨАТ багтсан болно.
- 5.2. Интернэрийн төлбөрийг гүйцэтгэгчийн **банкны** тоот төгрөгийн дансанд төлнө.

- 5.3. Хэрэглэгч Гүйцэтгэгчид мэдэгдэхгүйгээр үйлчилгээгээ түр зогсоосон нь төлбөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйл

- 6.1. Давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хуулийн зохицуулалт журам, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хорио, цээр, дайн, террорист халдлага, гадаад гарцын гэмтэл саатал, сүлжээний хэт ачаалал, доголдол, тасалдал, гоц халдварт өвчин зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.
- 6.2. Гэрээ хүчин төгөлдөр болсоноос хойш Талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаанаар тухайлбал, давагдашгүй нөхцөл байдлын улмаас болон гуравдагч этгээдийн хууль зөрчсөн санаатай буюу санамсаргүй байдлаар үйлдсэн үйлдэл, эс үйлдлийн улмаас Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй бөгөөд Хэрэглэгчид учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээхгүй.
- 6.3. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлүүдийн улмаас үүдсэн нөхцөл байдал 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд Талууд гэрээг цуцлах талаар саналаа албан бичгээр гаргах эрхтэй.

Долоо. Талуудын хариуцлага

- 7.1. Талууд нь Хавсралтуудад бичигдэх мэдээллийг үнэн зөв бөглөх хариуцлага хүлээнэ.
- 7.2. Талууд энэ гэрээний талаарх бүх мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх хариуцлагыг харилцан хүлээнэ.
- 7.3. Талуудын хооронд шилжүүлэн өгсөн нууц шинж чанартай мэдээлэл болон баримт бичигтэй зөвхөн гэрээний дагуу ажилд шууд холбоотой ажилтнууд танилцана.
- 7.4. Хэрэглэгчийн төгсгөлийн төхөөрөмж болон гэрээний 6-д заасан давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан үйлчилгээний тасалдал, доголдлыг гүйцэтгэгч компани хариуцахгүй.
- 7.5. Хэрэглэгч төлбөрөө төлөөгүйн улмаас Хэрэглэгчийн интернэтийн үйлчилгээ хаагдсанаас үүсэх аливаа хохирлыг Гүйцэтгэгч тал хариуцахгүй.
- 7.6. Хэрэглэгч төлбөрөө төлөөгүйн улмаас интернэт түр хаагдсан, нэхэмжлэх аваагүй, үйлчилгээг түр салгуулах болон гэрээ цуцлах хүсэлтээ утсаар мэдэгдсэн зэрэг нь төлбөр төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 7.7. Хэрэглэгч төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд нэхэмжилсэн төлбөрийн 0.2 хувьтай тэнцэхүйц алданги төлнө.
- 7.8. Гүйцэтгэгчийн суурилуулсан тоног төхөөрөмжийг тухай бүрт нь бүртгэж, суурилуулсан тухай акт үйлдэнэ.
- 7.9. Гэрээний хугацаа дуусгавар болох, гэрээ цуцлах тохиолдлуудад Хэрэглэгч нь Гүйцэтгэгчийн анхны төхөөрөмжүүдийг эвдэж гэмтээсэн, алдаж үрэгдүүлсэн тохиолдолд төхөөрөмжүүдийн үнийг төлж, Гүйцэтгэгчийг хохиролгүй болгоно.

Найм. Бусад зүйл

- 8.1. Талуудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, өмчлөгчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр байна.
- 8.2. Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 8.3. Санал зөрөлдөөн, маргааныг зөвшилцөөнөөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

- 8.4 Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй ба ажлын 5 хоногийн дотор өөрийн саналыг хариу мэдэгдэнэ. Талууд энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд гэрээний нэмэлтийг акт үйлдэн баталгаажуулна.
- 8.5 Гэрээний хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 8.6 Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан:

Гүйцэтгэгч төлөөлж:

Хэрэглэгчийг төлөөлж:

Виртуал линк ХХК-ийн Гүйцэтгэх захирал:

.....-ийн
.....

Борлуулалтын менежер:

.....

ГЭРЭЭНИЙ ТӨСӨЛ

Талуудын мэдээлэл

1. Хэрэглэгчийн мэдээлэл

№	Хэрэглэгч байгууллагын мэдээлэл	
1	Гэрээг хариуцах ажилтны нэр, албан тушаал	
2	Утасны дугаар	
3	Цахим шуудангийн хаяг	
4	Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хаяг	

2. Гүйцэтгэгч талын мэдээлэл

№	Гүйцэтгэгч байгууллагын мэдээлэл	
1	Гэрээг хариуцах ажилтны нэр, албан тушаал	Виртуал линк ХХК байгууллага хариуцсан менежер:
2	Утасны дугаар	
3	Цахим шуудангийн хаяг	sales@isp.mn
4	Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Бээжингийн гудамж ЖиБи оффис 801 тоот

ТӨЛБӨР ТООЦОО

	Үйлчилгээ авсан цэг:					
	Төлбөр төлөх хэлбэр	дансаар				
	Төлбөр төлөх хугацааны сонголт	Сар бүрийн 25-ний дотор төлнө.				
№	Үйлчилгээ	Цикл	Үнэ	тоо, ширхэг	Хөнгөлөлт	Нийт дүн
1	Суурилуулалтын төлбөр					0
2	Холболтын хурд (Гадаад 60мб) Дотоод хурд хязгааргүй	Сар бүр				
3	Серверийн үйл ажиллагаа	Сар бүр				
4	МТ хариуцах үйл ажиллагаа	Сар бүр				
	Нийт					

Нэмэлт тайлбар:

1. Гүйцэтгэгчийн гаргасан-ны өдрийн үнийн санал нь энэхүү төлбөр тооцооны салшгүй хэсэг болно.
2. Уг гэрээний 5.1 т заасны төлбөрөөр тооцно.